

“Мөнгөн өвлийн жингэнээ-2018” мөсний шагайн аймгийн аварга шалгаруулах тэмцээн Хутаг-Өндөр сумын Баатарван амралтын газар зохион байгуулагдлаа. Тэмцээнд Баян-Агт, Сайхан, Хангал, Бугат, Орхон, Хутаг-Өндөр сумын Хантай, Сургууль, Илчит Хутаг гэсэн 3 баг, Тэшиг сумын Тэшиг багууд, Тэшиг-Ус, Хилийн-0286-р анги гэсэн 3 баг, Орхон аймгийн Эрдэнэт-1, Эрдэнэт-2 баг, Булган сумын Нисэх, Авто тээвэр, БОАЖГ, МСҮТ, ЭӨЦСургуулийн нийт 16 багийн 96 харваач оролцож аваргуудаа тодрууллаа.

Мөнгөн өвөл-2018 тэмцээн Цэнгэлдэх хүрээлэнгийн мөсөн гулгуурын талбайд мөсний шагай, тэшүүр 4x100м буухиа, олс таталт, хөгжилтэй буухиа гэсэн төрлүүдээр зохион байгуулагдлаа. Тэмцээнд 27 байгууллагын 18 багийн тамирчид оролцож эхний байруудад шалгарсан багууд Хутаг-Өндөр суманд зохион байгуулагдах Мөсний шагайн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан байна.

Булган сумын Тэшүүрийн аварга шалгаруулах тэмцээн Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдаж Орхон аймгийн баг тамирчид сонирхогчдын журмаар оролцлоо. Булган сумын 3 сургуулийн 48 тамирчин 5 насны анилалаар оролцож багийн дүнгээр I байранд ЭӨЦС-ийн баг тамирчид, II байранд СДС-ийн баг тамирчид, III байранд I-12 жилийн баг тамирчид шалгарсан байна

Өсвөр тэшүүрчдийн Аймгийн аварга шалгаруулах тэмцээн Сэлэнгэ суманд зохион байгуулагдаж нийт 9 байгууллагын 103 тамирчин оролцлоо. Тус тэмцээнд багийн дүнгээр: I байр Баасанжаргал, О.Энхболд дасгалжуулагчтай Хутаг-Өндөр сум II байр Ц.Дэмбэрэлмаа дасгалжуулагчтай Хишиг-Өндөр сум III байр Баттулга дасгалжуулагчтай Могод сумын баг тамирчид шалгарлаа.

Булган аймгийн шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээн Булган суманд зохион байгуулагдаж нийт 20 багийн харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. Тус тэмцээний Тэргүүн байранд МУ-ын үлэмж дархан мэргэн Л.Түвшинжаргал ахлагчтай “Илчит металл” баг, Дэд байранд Б.Батцогоо ахлагчтай “Ханжаргалант” баг, Гутгаар байранд Д.Пүрэвсүрэн ахлагчтай Баян-Агт багийн харваачид шалгарч, Цуваа харвааны төрөлд: I байранд Г.Ганбаатар Сэлэнгэ сум, II байранд МУ-ын мэргэн Ө.Эрдэнэбат Ханжаргалант, III байранд Л.Эрдэнэбаяр Ханжаргалант багийн харваачид тус тус шалгарсан байна.



Мини волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Биеийн тамир, спортын газар, Хангал сумын ЗДТГазар, Ерөнхий боловсролын сургууль хамтран зохион байгууллаа. Тус тэмцээнд нийт 27 багийн 194 өсвөрийн волейболчид оролцож Эрэгтэй баг тамирчдаас: I байранд С.Алтангэрэл дасгалжуулагчтай Хангал сум, II байранд П.Баярсайхан дасгалжуулагчтай Бугат сум, III байранд Я.Нямсүрэн дасгалжуулагчтай БТСГазар, Эмэгтэй баг тамирчдаас I байранд Б.Батцоож дасгалжуулагчтай Бүрэгхангай сум, II байранд Я.Нямсүрэн дасгалжуулагчтай БТСГазар, III байранд Ю.Соёлмаа дасгалжуулагчтай Тэшиг сум, Багийн

дүнгээр: Тэргүүн байранд Я.Нямсүрэн дасгалжуулагчтай БТСГазар, Дэд байранд С.Алтангэрэл дасгалжуулагчтай Хангал сум, Гутгаар байранд Г.Гантулга дасгалжуулагчтай Хутаг-Өндөр сум тус тус шалгарч медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан байна.



Хаврын анхны нээлтийн “Цайт сурын харваа”-ны тэмцээн Булган сумын “Төв цэнгэлдэх” хүрээлэнгийн “Сурын харваа”-н талбайд зохион байгуулагдаж 9 багийн 32 харваач цэц мэргэнээ сорилоо. Тус харваанд спортын мастер-4, дэд мастер-3, Аймгийн мэргэн-4 оролцож, Эрэгтэй харваачдаас: I байранд Аймгийн мэргэн, спортын мастер Бүрэгхангай сумын харваач Д.Галбадрах, II байранд Бүрэгхангай сумын харваач С.Шижир, III байранд Хялганат тосгоны харваач Г.Содбилэг, IV байранд Бүрэгхангай сумын харваач Д.Мөнх-Эрдэнэ, V байранд Бүрэгхангай сумын харваач М.Болд, Эмэгтэй харваачдаас: I байранд Хишиг-Өндөр сумын харваач Д.Тавхар, II байранд Бүрэгхангай сумын харваач Б.Баярцэцэг, III байранд спортын дэд мастер, Аймгийн мэргэн Бүрэгхангай сумын харваач Л.Энхзул, IV байранд Бүрэгхангай сумын харваач Аймгийн мэргэн Б.Цэнгэлмаа, V байранд Хялганат тосгоны харваач П.Лхамаасүрэн нар тус тус шалгарлаа.



Ширээний шагайн Аймгийн аварга шалгаруулах тэмцээн 06 дугаар сарын 08-ны өдөр зохион байгууллаа. Тус тэмцээнд 14 багийн 60 гаруй тамирчид /ширээний шагай, морь уралдуудах, шүүрэх, няслах/ зэрэг төрдүүдээр оролцлоо

